



## БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:



НИЙЛҮҮЛЭГЧ:



“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв” ПАНН

гемофилийн эсрэг VIII, IX фактор нийлүүлэх гэрээ

2016 оны 2 сарын 16

Улаанбаатар хот

Нэг талаас “Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Монгол эм импекс” ХХК (“цаашид нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 2 дугаар сарын 16-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**Нэг: Нийтлэг үндэслэл**

- 1.1. Монгол улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахад энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2. Захиалагч нь Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв”-д оношуур нийлүүлэх № 2016 он 01 дугаартай тендерийн “Гемофилийн эсрэг 8, 9-р факторын (цаашид “бараа” гэх) нийт 1,182,841,000 ( нэг тэр бум нэг зуун наян хоёр мянга найман зуун дөчин нэгэн мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3. Гэрээний нийт дүн 1,182,841,000 ( нэг тэр бум нэг зуун наян хоёр мянга найман зуун дөчин нэгэн мянган). Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.4. Нийлүүлэгч нь 500 олон улсын нэгж савлагаатай Phizer компанийн гемофилийн эсрэг VIII факторыг (refacto FYIII) нийт 2519 флакон буюу 1,259,500 олон улсын нэгж, 500 олон улсын нэгж савлагаатай Phizer компанийн хүний гемофилийн эсрэг IX факторыг (refacto FIX) нийт 800 флакон буюу 400,000 олон улсын нэгж факторыг 2016 оны 6 дугаар сарын 01, 2016 оны 09 сарын 01-ны дотор тус тус нийлүүлж хүлээлгэн өгнө.

1.5. Дор дурьдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. (Цаашид гэрээний баримт гэх) Үүнд:

А. Гэрээ байгуулах тухай мэдэгдэл

Б. Үнийн хуваарь

В. Гэрээний тусгай нөхцөл

Г. Гэрээний ерөнхий нөхцөл

Д. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь

Гэрээ нь энд дурьдсан бараа нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурьдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

### **ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1. Захиалагч нь 1.4-т дурьдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн 20 хоногийн дотор нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.
- 2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг хэтрүүлсэн долоо хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.
- 2.3. Захиалагч нь тендерийн бичиг баримтанд заасан гемофилийн эсрэг VIII, IX факторын хүчинтэй хугацааг дуусах хүртэл факторыг тасалгааны хэмд хадгалах нөхцөлтэй байна. Нийлүүлсэн факторын хадгалалтын нөхцөл нь шаардлага хангаагүй тохиолдолд хүчинтэй хугацаанд зориулалтын хөргөгчинд хадгалахыг нийлүүлэгч тал хариуцна.
- 2.4. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн гемофилийн эсрэг VIII, IX факторын хүснэгтэнд заасан чанарын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах эрхтэй.
- 2.5. Захиалагчид гемофилийн эсрэг факторыг нийлүүлэгдэх үед 1,5 жилээс дээш хадгалалтын хугацаатай байх ба заасан хугацаанас богино хүчинтэй хугацаатай бол хүлээн авахгүй байх эрхтэй.

### **ГУРАВ. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, хадгалалалтын горим, чанарын шаардлагыг хангасан гемофилийн эсрэг VIII, IX факторыг нийлүүлэх үүрэгтэй.

- 3.2. Савлалт хаяглалтын материал нь тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Эмийн сав, баглаа боодол дээрх хаяглалт, тэмдэглэгээ нь эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шаардлагад нийцсэн байна. Цусны бэлдмэлийн үйлдвэрлэгчийн заасан нөхцөлийг бүрдүүлж тээвэрлэнэ. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг нийлүүлэх байгууллага бүрэн хариуцна.
- 3.3. Захиалагчид гемофилийн эсрэг факторыг нийлүүлэгдэх үед 1,5 жилээс дээш хадгалалтын хугацаатайг нийлүүлнэ.
- 3.4. Гемофилийн эсрэг факторыг шошго нь англи хэл дээр бичигдсэн байна. Гемофилийн эсрэг факторыг эмчилгээнд хэрэглэх зааврыг монгол хэл орчуулж захиалагчид өгнө.
- 3.5. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр долоо хоног тутам 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

#### ДӨРӨВ. ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

#### ТАВ. Бусад зүйл

- 5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
- 5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцөх боломжгүй болсон тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр 3 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний

Төвийн Ерөнхий нягтлан бодогч Д.Гунжээ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны  
өргөн чөлөө-13, С Зоригийн гудамж

Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

Монголэмимпекс ХХК-ийн бөөний  
төвийн эрхлэгч Н.Мөнхтуяа

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Их тойруу 39

Компанийн өөрийн байр

Утас: 323788 , Факс: 323877

ГЕМОФИЛИЙН ЭСРЭГ 8, 9-Р ФАКТОРЫГ НИЙЛҮҮЛЭХ БАГЦ № 14

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын нэр	Нэгж савлагааны тун хэмжээ /ОУН/	Савлагаа	Нийт шаардлагатай тун хэмжээ		Тодорхойлолт, техникийн үзүүлэлт	Чанарын шаардлага
					ОУН	фл		
1	Гемофилийн эсрэг VIII фактор Myetharma S.A Pfizer/	Antihemophilic factor VIII	500	фл	1.259.500	2519	рекомбинантын аргаар гаргаж авсан	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэгчийн үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын сертификатай</li> <li>• Америкийн (FDA) эсхүл Европын холбооны эрх бүхий байгууллагын чанарын сертификатай</li> </ul>
2	Гемофилийн эсрэг IX фактор Myetharma S.A Pfizer/	Antihemophilic factor IX	500	фл	400.000	800	рекомбинантын аргаар гаргаж авсан	

1. **Баглаа, боодол:** Савлалт хаяглалтын материал нь тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Эмийн сав, баглаа боодол дээрх хаяглалт, тэмдэглэгээ нь эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шаардлагад нийцсэн байна. Цусны бэлдмэлийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлийг бүрдүүлж тээвэрлэнэ. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг нийлүүлэх байгууллага бүрэн хариуцна.
2. **Бэлдмэлийн хадгалалтын нөхцөл, хэм:** +20+30 буюу тасалгааны хэмд хадгалах

**БАРАА НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ-ГЕМОФИЛИЙН ЭСРЭГ ФАКТОРЫГ НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ БАГЦ № 14**


№	Барааны нэр	Тун хэмжээ /ОУН/	Савлагаа	Нийт шаардлагатай тун хэмжээ		Хүчинтэй хугацаа	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
				ОУН	ФЛ		Бараа нийлүүлэх эцсийн хугацаа		Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
							2016-6-1 ны дотор	2016-09-01-ны дотор	
1	Гемофилийн эсрэг VIII фактор	500	Фл	1.259.500	2519	Нийлүүлэгдэх үед 1.5 жилээс дээш хадгалалтын хугацаатай	1300 фл	1219 фл	
2	Гемофилийн эсрэг IX фактор	500	Фл	400.000	800	барааны (5/6) нь өнгөрөөгүй, 2 ба түүнээс доош хадгалалтын хугацаатай барааны хувьд (3/4) нь өнгөрөөгүй +20+30 буюу тасалгааны хэмд хадгалах нөхцөлтэй	400 фл	400 фл	

**1. Баглаа, боодол:** Савлалт хаяглалтын материал нь тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Эмийн сав, баглаа боодол дээрх хаяглалт, тэмдэглэгээ нь эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шаардлагад нийцсэн байна. Цусны бэлдмэлийг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлийг бүрдүүлж тээвэрлэнэ. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг нийлүүлэх байгууллага бүрэн хариуцна.

**2. Бэлдмэлийн хадгалалтын нөхцөл, хэм:** +20+30 буюу тасалгааны хэмд хадгалах

**Баглаа, боодол:** Савлалт хаяглалтын материал нь тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Эмийн сав, баглаа боодол дээрх хаяглалт, тэмдэглэгээ нь эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шаардлагад нийцсэн байна. Цусны бэлдмэлийн үйлдвэрлэгчийн заасан нөхцөлийг бүрдүүлж тээвэрлэнэ. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг нийлүүлэх байгууллага бүрэн хариуцна.

Захиалагчийг төлөөлж :

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний  
Ерөнхий нягтлан бодогч  
Д.Гүнжээ   
Технологийн тасгийн эрхлэгч  
Н.Халиун 

Нийлүүлэгчийг төлөөлж :  
Монголэммипекс ХХК-ийн  
Бөөний төвийн эрхлэгч Н.Мөнхтуяа  
